

2015 оны эхний хагас жилийн тайлан мэдээ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд болон хамтран ажиллагсдынхаа энэ өдрийн амар амгаланг эрэн мэндчилж байна!

2015 оны эхний хагас жилд гаргасан шийдвэр болон ахиц амжилтаа та бүхэнд танилцуулж байгаадаа маш их баяртай байна.

Энэ хугацаанд бизнесийн орчны хувьд сүүлийн 2 жилтэй харьцуулахад таатай нөхцөл бүрдээд байна. Ерөнхий сайд Ч.Сайханбилэгээр ахлуулсан Эвслийн Засгийн Газар болон Рио Тинтогийн хоорондох “Оюу Толгой”-н 2 дугаар шатны боловсруулалтын гэрээ удаан хүлээгдсэний эцэст хийгдлээ. Ингэснээр Монгол Улс бизнесийн тавцанд эргэн гарч ирлээ хэмээн Барууны хэвлэл мэдээллээр тодорхойлж байна. Макро эдийн засгийн үзүүлэлт тогтвортой байж, инфляци нэг оронтой тоонд байгаа боловч эдийн засгийн өсөлт удааширсны улмаас БНХАУ дахь эрэлт буурч, Монголын нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ буурсаар байна.

Ард Холдингс төлөвлөсний дагуу Монголын Хөрөнгийн Бирж дээр гарах чиглэлд ахиц гаргалаа. Төлөөлөн Удирдах Зөвлөл хоёр удаа хуралдаж чухал шийдвэрүүд гаргаад байна. Хуулийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал 5 дугаар сард болж, BDO Аудит 2014 оны санхүүгийн тайланд аудитыг хийж гүйцэтгэлээ. Ард Санхүүгийн Нэгдэл доорх охин компаниуд бүгд “Хязгаарлалтгүй” дүгнэлт авсныг дуулгахад таатай байна. Удирдлагын захидлын дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг холбогдох удирдлагууд болон удирдах зөвлөл хүлээн авсан. Групп анх удаа олон улсын аудитын компаниар хянуулж, санхүүгийн тайлангийн нэгтгэлээ гаргаж байна.

Нийт хөрөнгө 36 тэрбум төгрөг болон өсөж, Ард Холдингсын үнэлгээ 35.5 тэрбум төгрөгөөр тогтоогдож, нэгж хувьцаанд ноогдох үнэлгээ 2,069.25 төгрөг болсон байна. (Хавсралтаас харна уу).

Ард Санхүүгийн Нэгдэл нь 2 дахь жилийн тайлангаа бэлэн болгож нийт хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчиддаа хүргүүлж байгаа. Цахим хувилбарыг нь эндээс сонирхох боломжтой: <http://bit.ly/1CSOOvD>. Компани IPO-н маркетингийн бодлогоо эрчимжүүлэх үүднээс нийгмийн хариуцлага болон сурталчилгааны ажлууд дээр анхаарал хандуулсаар байна. Бид 5 дахь удаагийн Монголын Эдийн Засгийн Чуулганыг ивээн тэтгэж, Венецийн Biennale дахь Монгол улсын оролцоог дэмжиж ажиллалаа. Мөн Jean Jacques Annaud- ийн "Чонон Сүлд" киноны Улаанбаатар дахь нээлтэнд санхүүгийн туслалцаа үзүүлснээс гадна эдийн засаг болон бизнестэй холбоотой олон чуулга уулзалт болон хурлыг дэмжин ажилласан байна. Саяхан болж өнгөрсөн “Авьяаслаг Азичууд” уралдаант тэмцээнд амжилттай оролцоод эх орондоо эргэн ирсэн Хөсөгтөн хамтлагийн анхны тоглолтыг ивээн тэтгэж ажиллалаа. Энэ жил бид 29 дүгээр сургуулийг зорин очиж сурагч нарт бэлэг тараах уламжлалаа хадгалав. Ард болон охин компаниуд нь Америкийн худалдааны танхим, Монголын Бизнесийн Зөвлөл, Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, CEO клуб, ББСБайгууллагуудын нэгдэл болон Даатгагчдын холбоо зэрэг хэд хэдэн бизнес нэгдлүүдийн гишүүн бүрэлдэхүүнд багтан хамтран ажиллаж байна.

Ард Холдингс нь Ерөнхий Сайдын Эдийн Засгийн Зөвлөл ба Улаанбаатар Хотын Худалдааны Танхимын үйл ажиллагаанд идэвхитэй оролцдоггоороо олонд танигдаж, Ж.Оюунгэрэл, Ч.Ганхуяг болон Б.Нэмэхбаатар нь Улаанбаатар Хотын Худалдааны Танхимийн төлөөлөн удирдах зөвлөлд багтан ажиллаж байна.

Бид Монголын хамгийн анхны олон нийтэд нээлттэй, цогц санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч нэгдэл компани болох зорилтынхоо хүрээнд гадаад харилцаа, олон нийтийн яриа, хэвлэл мэдээллийн ярилцлага, зар сурталчилгаа зэргийг ашигладгийг дурдъя. Түүнчлэн, бид Ард гэсэн

брэндийн кампанит ажлыг эхлүүлж, ердөө 18 сарын дотор Монголын бизнесийн хүрээнд танигдаж амжсан нь та бүхний цаашдын ажил үйлсэд улам их урам зориг өгнө гэдэгт эргэлзэхгүй байна.

Ард Холдингс

Ард Холдингс нь гүйцэтгэх захирал, гүйцэтгэх захирлын туслах болон 2 нягтлан бодогчтойгоор буюу боломжит хамгийн бага 4 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Жолоочийг Ард Актив ХЗХ-с цалинжуулж байгаа ба нэг нягтлан бодогч нь Тэнгэр Системс ХХК дээр давхар ажиллаж байна. Ресепшний орон тоо одоогоор эзгүй байгаа ба 3 дугаар улиралд багтаан дүүргэх болно. Мөн дотоод аудитор болон нягтлан бодогч нэмж шалгаруулж авах төлөвлөгөөтэй байна.

Компани 2015 оны эхээр 20 хувийг нь эзэмшдэг Өнгөт Хэвлэлийн оффисын байранд нүүж орлоо. Оффисын дотоод заслыг бүрэн хийж өнгө үзэмж сайтай болгон шинэчлэн засварласан бөгөөд харилцагч, хөрөнгө оруулагч нарыг хүлээн авахад таатай орчинг бүрдүүлээд байна.

Манай компанид гарсан нэгэн таатай мэдээ нь Adveq-ийн ноён Бруно Рашле 6 дугаар сараас эхлэн Ард Холдингсийн шинэ хувьцаа эзэмшигчээр нэгдэж, хамтран ажиллаж эхлээд байна.

Ард Холдингс нь эхний хагас жилийн сүүлээр банкин дахь бүх өр төлбөрөө төлснөөр цэвэр зээлдэгчээс зээлдүүлэгч болж өргүй компани боллоо. Бид шинэ хөрөнгө оруулалт хийхтэй холбоотойгоор олон улсын хамтрагч байгууллагаасаа зээл авсан байсан ба 2008 оноос хойш энэ нь өргүй болсон анхны тохиолдол болж байна. Өнгөрсөн 5 дугаар сард Ард Холдингс нь Төрийн банкин дахь зээлийн сүүлийн төлбөрөө төлж дуусгасан. Мөн эхний зургаан сарын байдлаар долларын гаргасан зээлийн хэмжээг 750 мянган доллар хүртэл нэмэгдүүлжээ.

Компани нь Ард Кредит болон Ард Даатгалын баланс дээрх хуучин авлагуудыг хааж хувь нэмрээ оруулж өгснийг дурдах нь зүйтэй. Бид нийт 500 сая төгрөгийн үнийн дүн бүхий хувьцаа солилцооны гэрээг амжилттай хийж өөрийн эзэмшлийн хувиа нэмэгдүүлсэн бөгөөд Ард Кредит ББСБ-ийн 58 хувийг, Ард Даатгалын 55 хувийг тус тус эзэмшдэг болоод байна.

Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгэлтэй Жинст Увс ХК-ийн багцыг худалдан авахын тулд Ард Секюритиз ҮЦК-аас мэргэжлийн туслалцаа авсан. Одоогоор бид Жинст Увс ХК-ийн 84 хувийг худалдан авсан ба нэгдэх замаар биржид бүртгүүлэхээр төлөвлөж байна.

Маш удаан хугацааны туршид хэлэлцсэний үр дүнд бид Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн 4.26 хувиа ТСН-ийн одоогийн хувьцаа эзэмшигч болох Монголиа Оппортьюнитиз Фондад нэгж хувьцааг нь 8.77 доллараар худалдахаар шийдлээ. Энэхүү хэлцлийн арилжааны нийт дүнг одоогийн долларын ханшаар тооцоолбол ойролцоогоор 13 тэрбум төгрөг болохоор байна. Үүний 5.3 тэрбум төгрөг нь Алтай Холдингс ХХК-ийн ЮБиАйЖи ХХК болон Аполло Вентурс ХХК-ийн эзэмшиж буй хувьцааг буцаан худалдаж авахад зарцуулагдах болно. 2014 оны 12 дугаар сард хийгдсэн гэрээний дагуу нэгж хувьцааг 1500 төгрөгөөр үнэлсэн байгаа. Хэлцэл амжилттай хийгдсэний дараагаар татварын дараах ашиг 6 тэрбум төгрөг болно хэмээн таамаглаж байна.

Манай хамтрагч байгууллага болох Техник Технологийн Дээд Сургууль нь ЗАГ ХХК-ийн эзэмшдэг 50 хувийг худалдан авах боломжит тохиролцоо хийсээр байгаа билээ. 8 дугаар сард бид энэ асуудлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хэлэлцүүлэг хийж тодорхой чиглэл гаргана. Удирдлагууд банкны салбарт хөрөнгө оруулалт хийх боломжийг хайж байна.

Охин компаниудын онцлох үйл явдлууд

Техник Технологийн Дээд Сургууль

- ТТДС-ийн ТУЗ 100 сая төгрөгний ноогдол ашиг тараах шийдвэр гаргасан.
- ТТДС нь нийт 1,977 оюутан, сурагчидтай болоод байна.
- Үндэсний Аудитын Газраас улсын төсвийн хөрөнгөөр аудитын шалгалт хийсэн. Мөн ТТДС нь олон улсын аудитын компаниар аудит хийлгүүлсэн анхны хувийн сургууль болсон.
- Sakura Science програм нь ТТДС-ийн дэргэдэх Монгол Коосэн сургуулийн сурагчид болон багш нарт Японд дадлага хийх боломжийг бүрэн гаргаж өгч дэмжлэг үзүүлсэн. Хамтран ажиллах гэрээ нь Японы Окинава Коосэн болон Нагаокагийн Техникийн Их Сургуулиуд дунд зурагдсан билээ.
- Орон нутгийн тэмцээнүүдэд амжилттай оролцсон ТТДС-ийн 3 оюутан 8 дугаар сард Бразил улсын Сан Пауло хотод болох Дэлхийн Ур Чадварын 43 дахь тэмцээнд оролцох эрх авсан баярт үйл явдал болсон.
- Улаанбаатар Shapers Hub-ийн зүгээс санаачлан зохион байгуулж, Оюу Толгой компаниар санхүүжүүлж буй дунд сургуулийн хүүхдүүдэд үндэсний гэр хэрхэн барих талаар сургах зорилготой “Гэр” төсөлд сургууль нь амжилттай оролцож, тендерийн эрх авсан.
- Хэвлэх үйлдвэрийн үйл ажиллагаа явуулах боломжит хэлэлцээрүүд явагдаж байгаа бөгөөд 3 дугаар улирал гэхэд дуусгах төлөвлөгөөтэй байна.
- Мөн сургууль нь Sumitomo-той Барилга Байгууламж ба Техникийн Төвийг дэмжих талаар хамтран ажиллах хэлэлцээрүүд хийж байна.

Ард Кредит

- Ард Кредитын ТУЗ нь 2014 оны цэвэр орлогынхоо 30 хувийг ноогдол ашиг болгон хуваарилаж тараана гэж шийдсэн нь Нэгдэлийн хувьд түүхэн үйл явдлын нэгэн шинэ хуудсыг нээж байгаа гэж удирдлагууд үзэж байна.
- Ард Холдингс дээрх хувьцааг солилцох саналыг Ард Кредитэд гаргасан бөгөөд гүйцэтгэх захирал Ч.Ганзориг нь Ард Кредитийн 8 хувийг сольж Ард Холдингс нь 58 хувийг эзэмших болсон.
- Худалдаа Хөгжлийн Банкин дээр 250 сая төгрөгний зээлийн шугам нээлгэлээ.
- Ард Холдингсын тусламжтайгаар Интергрупп Интернейшнл дээрх 340 сая төгрөгний зээлийг төлж барагдуулсан.
- Ард Кредит нь анхны жилийн тайлангаа Монгол ба Англи хэл дээр нийтэлж гаргасан.
- Шинэ вэб хуудас болон онлайн зээлийн програмаа хэрэглэж эхлээд байна.
- Эдийн засгийн орчин таагүй байсан боловч Ард Кредитын цэвэр орлого эхний хагаст 195 сая төгрөгт хүрээд байна. Гэсэн хэдий ч чанаргүй зээлийн өрийн дүн өсвөл компанийн үр ашигт сөргөөр нөлөөлж болзошгүй билээ.

Ард Даатгал

- Тайлангийн үеэр томоохон хувьцааны солилцоо Ард Холдингс ба ВенчүрсУан БиВи дунд явагдаж, Ард Холдингс нь компанийн ихэнх буюу 55.3 хувийг эзэмшихээр болсон. Зарим нэг хувьцаа эзэмшигчдийн асуудлын улмаас хувьцаа эзэмшилтийн өөрчлөлтийн эцсийн бүртгэл хийгдэж дуусаагүй байна.
- ТУЗ ба ТУЗ-ийн хороодын хурлыг зохих ёсоор 2015 оны эхний улиралд зарлан хувьцаа эзэмшигчдэд 214 сая төгрөгний ноогдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан. Компани нь

жил бүр ноогдол ашгийн төлөлтөө бүртгэхийн зэрэгцээ, СЗХ-ноос тавьсан шаардлагыг биелүүлэхийн тулд дүрмийн сангаа 750 сая төгрөгөөр нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

- Сүү ХК-ийн гүйцэтгэх захирал ноён Б.Гантулга ТУЗ-д хараат бус гишүүнээр ажиллаж эхэлсэн.
- 2015 оны 3 дугаар сард Ард Холдингсын тусламжтайгаар Интергрупп Интернэйшнл ХХК-ийн 208.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн авлагыг эцэслэн шийдвэрлэх гэрээг зурлаа.
- Програм хангамжийн шинэчлэлийн хоёр дахь үе шат нь амжилттай хэрэгжиж эхэлсэн. Нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн хувьд мөн шинэчлэлтүүд хийсэн ба даатгалын төлбөрийн тухай мэдээлэл хүргэх систем хэрэгжиж, дотоод сүлжээ сайжирсан.
- Шаардлагын дагуу ажиллагсдыг сургалт хөтөлбөрт байнга хамруулж байна.
- Оффисын 660 метр квадрат шинэ байртай болж, барилгын дотоод заслууд хийгдэж байна. Нийт төлөвлөсөн хөрөнгө оруулалтын 50 хувь нь хийгдсэн бөгөөд компани нь 2015 онд багтаан өөрийн шинэ оффис руу шилжих болно.
- Эдийн засаг удааширч, бизнесийн үйл ажиллагаа сайнгүй байгаа хэдий ч тайлант хугацаанд нийт хураамжийн орлого 4.4 тэрбум төгрөг болсон байна.
- Гүйцэтгэх захирал хатагтай Д.Чулуунцэцэг нь 2015 оны 5 дугаар сард Монголын Даатгагчдын Холбооны ерөнхийлөгчөөр томилогдон ажиллаж байна.

Ард Секюритиз

- Тайлант хугацаанд компанийн ТУЗ-ийн хурал 2 удаа зарлагдаж, 2015 оны төсөв төлөвлөгөөг баталсан.
- Оноосон нэрийн өөрчлөлт нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлагдсан бөгөөд нэрийн өөрчлөлтөө МХБ, ҮЦТТХТ болон арилжааны банкуудад бүртгүүлсэн.
- Ард Холдингсын жижиг хувьцаа эзэмшигчдийг цөөлж, 500 мянган долларын шинэ хөрөнгө оруулалтыг Ард Холдингст амжилттай зуучилж өгсөн.
- Ард Холдингсыг ҮЦТТХТ-д хаалттай хувьцаат компани хэлбэрээр бүртгүүлэхээр бэлтгэл ажил хийгдсээр байна. МХБ дээр бүртгэгдэх ажлыг 2015 оны 4 дүгээр улиралд багтаан дуусгахаар төлөвлөж байна.

Ард Актив

- Бүх Гишүүдийн Хурлыг 2 дугаар улиралд зарлан хуралдуулсан ба гишүүдийг хамруулсан спортын өдөрлөгийг зохион байгууллаа.
- Гишүүдтэйгээ илүү ойр байхыг эрхэмлэж Фэйсфүүк дээр үйл ажиллагаагаа идэвхжүүлж эхэлсэн.
- Төлбөр тооцооны эрх авах өргөдлөө СЗХ-д хүргүүлсэн.
- Тэргүүлэгчдийн зөвлөл, Хяналтын зөвлөл болон Зээлийн хорооны гишүүдийн сонгуулийг зохион байгуулж, гишүүдийн товч намтрыг баталгаажуулахаар СЗХ-д хүргүүлээд байна.
- Зээл, хадгаламжийн бүтээгдэхүүнүүдийн талаарх бодлого болон журмуудыг шинэчлэн найруулж баталсан.
- Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 70.6 сая төгрөг болж өссөн.
- Нийт гишүүдийн тоог 381 болсон ба 45 ажилчинтай 2 шинэ компани тэтгэврийн санд элссэн байна.

Ард Менежмент

- Сангийн менежментийн компани болох Ард Менежмент ХХК нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд холбогдох тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ СЗХ-нд гаргасан байгаа.
- Түр ТУЗ болон компанийн удирдлагыг томилсон байгаа ба тусгай зөвшөөрөл гарсны дараагаар Группын ТУЗ-ийн хурлаар дахин хэлэлцэх болно.
- Менежментийн компанийг үүсгэн байгуулахад шаардлагатай хөрөнгийн доод хэмжээ болох 100 сая төгрөгийг Ард Холдингс нь богино хугацааны санхүүжилтээр шийдвэрлэсэн.

Эхний зургаан сарыг амжилт бүтээлээр дүүрэн өнгөрүүлсэнд та бүхэнд чин сэтгэлээсээ баяр хүргэж, цаашдын ажил үйлсэд тань сайн сайхан бүхнийг хүсэж байна. Үлдэж буй хугацаанд Ард нь Монголын хөрөнгийн бирж дээрх бүртгэлтэй компани болох болно гэдгийг дурдъя. Эдгээр төлөвлөсөн ажил үйлсэд амжилт хүсье!

Хүндэтгэсэн,



Гүйцэтгэх захирал
Чулууны Ганхуяг

Энэхүү тайланд үнэлгээ, Монголиа Оппортюнитиз Фанд-тай хийсэн санамж бичиг, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, санхүүгийн үзүүлэлт зэргийг хавсаргав.

Үнэлгээ

Сая төгрөг

	Үнэлгээ		Хувь (%)	Үнэлгээний суурь
	12/31/2014	6/30/2015		
Хөрөнгө оруулалт				
ТэнГэр Санхүүгийн Нэгдэл	11,684.77	12,103.62	4.26	Худалдааны үнэлгээ/ 706596*8.77\$/
Техник Технологийн Дээд Сургууль	9,824.90	9,824.90	50.00	Үндсэн хөрөнгийн үнэлгээ
Ард Даатгал	6,637.20	6,637.20	55.31	Сүүлийн худалдааны үнэлгээ
Ард Кредит	1,600.00	1,852.90	58.00	Хөрөнгө оруулалтын үнэлгээ
Ард Секюритиз	983.00	983.00	100.00	Мөнгөн урсгал
Номын Хишиг	1,382.40	1,382.40	20.00	Өмчийн үнэлгээ
Бусад	218.81	218.81		Хөрөнгө оруулалтын үнэлгээ
Урт хугацааны хөрөнгө оруулалт	32,331.09	33,002.83		
Богино хугацааны хөрөнгө оруулалт	958.61	2,020.32		Хөрөнгө оруулалтын үнэлгээ
Нийт хөрөнгө оруулалт	33,289.70	35,023.16		
Компанийн хөрөнгө				
Үндсэн хөрөнгө	897.32	1,073.73		
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	408.47	211.23		
Дансны авлага/(өглөг)	(595.95)	(728.76)		
Нийт	709.84	556.20		
НИЙТ ҮНЭЛГЭЭ	33,999.54	35,579.35		

Эргэлтэнд гаргасан хувьцааны тоо	16,795,333	17,194,364
Нэгж хувьцааны үнэ	2,024.34	2,069.25

Санхүүгийн тайлан /2015.06.30/

Мянган төгрөг				
ТАЙЛАН ТЭНЦЭЛ	2014.12.31	2015.06.30	Өөрчлөлт	%
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	408,470	211,232	-197,238	-48
Авлага, БХХО	1,546,292	2,132,074	585,782	38
Урьдчилж төлсөн тооцоо	79,376	144,106	64,730	82
Үндсэн хөрөнгө	447,862	534,030	86,168	19
УХХО	32,331,089	33,002,833	671,744	2
НИЙТ ХӨРӨНГӨ	34,813,089	36,024,275	1,211,186	3
Өглөг			0	
Дансны өглөг	985,727	845,914	-139,813	-14
ОАТ өглөг	1,290	419,784	418,494	32441
Зээл	0	812,103	812,103	100
Хойшлогдсон татварын өглөг	5,212,734	967,355	-4,245,379	-81
Урт хугацаат өглөг	136,179	129,703	-6,476	-5
Нийт өглөг	6,335,930	3,174,859	-3,161,071	-50
Өмч				
Хувь нийлүүлсэн хөрөнгө	1,679,533	1,719,436	39,903	2
Хувьцааны ханшийн нэмэгдэл	9,298,761	9,929,061	630,300	7
Бусад дансны хөрөнгө	13,799	13,799	0	0
Хуримтлагдсан ашиг	17,485,066	21,187,120	3,702,054	21
Нийт өмч	28,477,159	32,849,416	4,372,257	15
ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	34,813,089	36,024,275	1,211,186	3

* Хойшлогдсон татварын өглөг нь хөрөнгө оруулалтын дахин үнэлгээнээс үүссэн бөгөөд хувьцаа худалдсанаас бодитоор олз гарз үүсэх үед хэрэгжинэ.

Мянган төгрөг

ОРЛОГЫН ТАЙЛАН	2014.12.31	2015.06.30
Хөрөнгө оруулалтын орлого	107,759	4,153,029
Хүүгийн орлого	154,766	79,629
Ноогдол ашгийн орлого		179,029
Түрээсийн орлого		74,901
Зах зээлийн үнэлгээний орлого	831,435	671,745
Удирдлагын зардал	819,600	387,727
Ханшийн өөрчлөлийн ашиг/(алдагдал)	43,802	63,227
Хүүгийн зардал	151,050	40,626
Муу зээл		449,927
Бусад зардал	224,963	99,019
Татварын өмнөх ашиг/(алдагдал)	(212,617)	4,244,261
Орлогын албан татвар	40,153	477,880
Хойшлогдсон татварын зардал	83,144	67,174
Жилийн ашиг/(алдагдал)	(335,913)	3,699,207

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц /2015.06.30/

№	Хувьцаа эзэмшигчдийн нэрс	Гарахын өмнөх/2015.06.30		Гарсны дараах хувилбар	
		Хувьцааны тоо	Эзэмшигчийн хувь	Хувьцааны тоо	Эзэмшигчийн хувь
1	ЮуБиАЙЖи ХХК	1,907,059	11.09	-	0.00
2	Интергрупп Интернэйшнл ХХК	1,871,276	10.88	1,871,276	13.76
3	Аполло Вентурс ХХК	1,690,000	9.83	-	0.00
4	Луна Энд Луна ХХК	1,373,801	7.99	1,373,801	10.10
5	ВенчурсУан БиВи	1,304,043	7.58	1,304,043	9.59
6	ГАНХУЯГ Чулуун	1,290,000	7.50	1,290,000	9.49
7	МАК ХХК	873,000	5.08	873,000	6.42
8	НЭМЭХБААТАР Баяртогтох	507,834	2.95	507,834	3.73
9	БРУНО Рашле	461,016	2.68	461,016	3.39
10	БҮРЭН-ЭРДЭНЭ Хулдорж	457,300	2.66	457,300	3.36
11	СОРОНЗОНБОЛД Лхагвасүрэн	453,210	2.64	453,210	3.33
12	ГЭРЭЛТУЯА Сэдбазар	452,000	2.63	452,000	3.32
13	УЯНГА Галням	431,589	2.51	431,589	3.17
14	СЭРГЭЛЭН Мөнх-Очир	350,794	2.04	350,794	2.58
15	БАТ-ОЧИР Дүгэрсүрэн	313,650	1.82	313,650	2.31
Нийт		13,736,572	79.89	10,139,513	74.57
Бусад хувьцаа эзэмшигчид		3,457,792	20.11	3,457,792	25.43
НИЙТ		17,194,364	100.00	13,597,305	100.00

